

**ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХҮЙН ТУХАЙ ХУУЛЬ БОЛОН ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙДЫН  
2019 ОНЫ 253 ДУГААР ТУШААЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ДАЛАЙН ЗАХИРГААНААС ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2020 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн байдлаар

Хэрэгжүүлэх заалт	Хэрэгжилтийн байдал
1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль түүнийг дагаж гарсан дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг хангах, удирдлага, зохион байгуулалт, хяналтын хариуцлага тогтолцоог боловсронгуй чиглэлээр:	<p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажилласан талаарх тайлант 2019 оны жилийн эцсийн байдлаар гарган ЗТХЯ-нд 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 1/299 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>ХАБЭА-н тухай хууль, тогтоомж /дүрэм, журам, стандарт болон Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаал, Далайн захиргааны даргын тушаалаар баталсан журмууд/-ийн хэрэгжилтэд Далайн захиргааны ХАБЭА-н орон тооны бус зөвлөл болон Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан тохиолдолд осол хордлогын шалтгааныг тогтоох, үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комисс хамтран хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын дагуу шинэчлэн боловсруулж, батлуулсан. Уг тодорхойлолтод Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах, холбогдох сургалтад хамрагдах, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаатай байнга танилцах, ХАБЭА-н З шатны үзлэг шалгалтыг хийж хэвшүүлэх заалтуудыг тус тус тусгасан.</p> <p>Байгууллагын “Үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх орон тооны бус комисс” нь Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 269 дүгээр тогтоолоор батлагдсан “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”-ийн дагуу “Ажилтнуудын ажилдаа ирэх, буцах замын маршрутыг баталгаажуулах маягт”-ыг Даргын 2020 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 17 дугаар тушаалаар батлуулав. Уг маягтын дагуу ажилтнуудын ажилдаа ирэх, буцах замын маршрутыг гаргуулан ажиллав.</p> <p>“Далайн захиргааны ажилтнуудын албан томилтоор ажиллах тухай журам”-ын төсөлд нийт ажилтнуудын саналыг тусган шинээр боловсруулж, Далайн захиргааны даргын 2020 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 37 дугаар тушаалаар батлуулан ажиллаж байна.</p> <p>Усан замын тээврийн хяналтын улсын байцаагч нарт өдөр тутмын аюулгүй ажиллагааны зааварчилгааг цахим хэлбэрээр өгч байх боломжийг бүрдүүлж, хэрэгжилтэд хяналт тавих ажлыг усан замын тээврийн</p>

	<p>хэрэгслийн 2020 оны хөвөлтийн улирлын хугацаанд хэрэгжүүлэн ажилласан. Энэ талаар холбогдох мэргэжилтнүүдийн 2020 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган гүйцэтгэлд нь хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Зам, тээврийн салбарын байгууллагуудын ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтнуудыг Зам, тээврийн хөгжлийн дэд сайд Л.Халтар 2020 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр хүлээн авч хийсэн уулзалт, хэлэлцүүлгийн үеэр салбарын хэмжээнд ХАБЭА-н хууль, тогтоомжийн хэрэгжилтийн байдалд үнэлэлт дүгнэлт өгч, зарим үүрэг чиглэлийг өгсөн болно. Уг хэлэлцүүлэгт Далайн захиргааны ХАБЭА-н орон тооны бус зөвлөлийн нарийн бичгийн дарга оролцсон.</p> <p>Энэхүү уулзалт, хэлэлцүүлгийн үеэр Зам, тээврийн хөгжлийн дэд сайдаас өгсөн үүрэг даалгаврын дагуу байгууллагын ХАБЭА-н орон тооны бус зөвлөл хуралдаж, дараах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>- ХАБЭА-н гурван шатны хяналтыг зохион байгуулах журмын хэрэгжилтийг хангах, хяналтын дэвтэр хөтлөлтийг сайжруулахад анхааран ажиллаж байна.</li> <li>- Далайн захиргааны ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтод ХАБЭА-н тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх талаар нэмэлт заалт оруулж, батлуулаад байна.</li> <li>- Ажлын байранд гарч болзошгүй аливаа осол, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор ажлын байр тус бүрд тохирсон аюулгүй ажиллагааны зааварчилгааг шинээр болон шинэчлэн боловсруулах ажлыг мэргэжилтнүүдийн оролцоотойгоор хийж хэрэгжүүлсэн. Үүнд оффисын ажилтны өдөр тутмын зааварчилгаа болон бусад ажлын байрны онцлогт тохирсон зааварчилгааг ажилтнуудын саналд үндэслэн боловсруулж, Далайн захиргааны даргын 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 41 дүгээр тушаалаар батлан хэрэгжүүлж байна. <b>Оффисын ажилтнууд ажил эхлэхээс өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаатай танилцан өдөр тутмын зааварчилгааны бүртгэлийн дэвтэрт тэмдэглэж хэвшээд байна.</b></li> </ul>
2. Байгууллагын үйл ажиллагааны онцлог, ажиллагсдын тооноос хамаарч Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан, бүтэц орон тоог бий болгох чиглэлээр:	“Далайн захиргааны ХАБЭА-н орон тооны бус зөвлөл”-ийг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан зөвлөлийн ажиллах журмыг Далайн захиргааны даргын 2019 оны 65 дугаар тушаалаар батлуулан ажиллаж байна.

<p>3. Ажлын хувцас, хамгаалах хэрэгслийн хангарт, чанар, хэрэглээнд шалгалт хийж хяналт тавих, аюулгүй байдлын самбар, санамжуудыг шинэчлэх, шинээр байрлуулах чиглэлээр:</p>	<p>Далайн захиргааны ХАБЭА-н орон тооны бус зөвлөлийн 2020 оны төлөвлөгөөний дагуу усан замын тээврийн хяналтын улсын байцаагчдын ажлын хувцас, хамгаалах хэрэгслийн хангарт, чанар, хэрэглээнд шалгалт хийх, ажлын байран дахь ХАБЭА-н нөхцөлийг бүрдүүлэх талаар холбогдох зардлыг Байгууллагын үйл ажиллагааны 2020 оны орлого, зарлагын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлсэн.</p> <p>Усан замын тээврийн хяналтын улсын байцаагчдыг ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангах ажлыг үед шаттай хэрэгжүүлэн ажилласан.</p> <p>Усан замын тээврийн хяналтын улсын байцаагч нарт өдөр тутмын аюулгүй ажиллагааны зааварчилгааг цахим хэлбэрээр өгч байх боломжийг бүрдүүлэх, зааварчилгааг өгч хэвших, хэрэгжилтэд хяналт тавих ажлыг усан замын тээврийн хэрэгслийн 2020 оны хөвөлтийн улирлын хугацаанд хэрэгжүүлээд байна. Энэ талаар холбогдох мэргэжилтнүүдийн 2020 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган баталсан.</p> <p>Байгууллагын хэмжээнд хариуцсан салбартаа хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангах ажлын хүрээнд Хөвсгөл аймгийн Хатгал тосгон дахь усан замын тээврийн хяналтын завь, катеруудын усан зогсоолын хашилага хаалтыг засч сайжруулах тохижилтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Уг зогсоол дээр хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангахтай холбогдсон тэмдэг, тэмдэглэгээ, анхааруулах самбарыг байрлуулав.</p>
<p>4. Ажилтныг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зохих сургалтад хамруулж, шалгалт авч, "Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Сургалтын зохион байгуулалт. Үндсэн дүрэм" MNS 4969:2000 үндэсний стандартын дагуу аюулгүй ажиллагааны зааварчилгааг ажлын байрны онцлогт тохируулан тогтмол өгч, эрүүл, аюулгүй нөхцөлд ажиллах дадлыг ажилтан бүрт эзэмшүүлсэн байх;</p>	<p>Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас жил бүрийн 04 дүгээр сарын 28-ны өдрийг "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн Дэлхийн өдөр" болгосонтой холбоотойгоор ЗТХЯ-наас зохион байгуулж буй "Ажлын байран дахь хүчирхийлэл, дарамтаас урьдчилан сэргийлэх" чиглэлээр ажиллах урианд нийцүүлэн "ХАБЭА-н сарын аян-2020" арга хэмжээний хүрээнд байгууллагын хэмжээнд нэг сарын хугацаанд Далайн захиргааны ХАБЭА-н орон тооны бус зөвлөл, Үйлдвэрлэлийн осол, хурц, хордлогыг судлан бүртгэх комиссоос дараах арга хэмжээг хамтран зохион байгуулсан.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Далайн захиргааны нийт ажилтнуудад стрессийн тухай ойлголт, стрессст өртөхгүй байх, дэлхий нийтээр тархаад буй Ковид-19 цар тахлын халдвараас урьдчилсан сэргийлэх, ажил, амралтын цагийг зөв зохицуулж, биеийн дархлааг сайжруулах талаар эрүүл мэндийн байгууллагаас өгч буй зааварчилгаанд тулгуурлан ухуулга сурталчилгаа, танин мэдэхүйн мэдээ, мэдээллээр хангах ажлыг тогтмол зохион байгуулсан. Түүнчлэн ажлын байрны стрессийн түвшинг тодорхойлох зорилготой сэтгэл зүйн сорил тестийг нийт ажилтнуудаас авсан нь тэдний мэдлэгийг бататган сайжруулсан ихээхэн ач холбогдолтой арга хэмжээ болсон.</li> </ul> <p>Хүний сэтгэл зүйд сөргөөр нөлөөлж, стресс бухимдал үүсгэдэг хүчин зүйлсийг судалж, стрессийн түвшинг тодорхойлох тестийг боловсруулсан. Зохион байгуулагчдын зүгээс хувь хүний нууц, дотоод асуудалд хэт үнэлэлт дүгнэлт өгөхөөс зайлсхийж зөвхөн ажлын байран дахь стрессийн түвшинг тодорхойлоо зорьж, сорилд хамрагдаж буй ажилтны нэрийг тестийн хуудаст тэмдэглээгүй болно. Далайн захиргааны нийт 24 ажилтныг хамруулсан сорил, тестийг дүгнэж үзэхэд хэвийн буюу хамгийн бага стресстэй 15, бага болон дунд зэргийн стресстэй 6, дундаас дээш түвшний стресстэй 3 хүн тус тус байна гэсэн дүн гарсан юм. Энэхүү сорилын дүнг нийт ажилтнуудад танилцуулж, ажлын байран дахь</p>

	<p>стрессийг багасгах, бууруулах талаар хувь хүнд чиглэсэн арга хэмжээнд анхаарч, түүний учир шалтгааныг зөв тодорхойлж стресс бухимдлаас сэргийлэх арга хэмжээ авах талаар санал зөвлөмжийг өгч ажиллав.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Далайн захиргааны удирдлагын зүгээс 7 хоног бүрийн Бямба гарагийн өглөө бүр дугуйн аялал зохион байгуулж байх уриалгыг гаргасныг ажилтнууд дэмжиж, идэвхтэй оролцож байна. Уг уриалга гаргаснаас хойшх хугацаанд дугуйн аяллыг 3 удаа зохион байгуулаад байгаа бөгөөд дугуйн аялалд давхардсан тоогоор нийт 20 орчим ажилтныг оролцуулсан байна.</li> </ul> <p>“Үйлдвэрийн ослын төрөл, түүнээс урьдчилан сэргийлэх нь” зэрэг сэдвээр онлайн сургалтыг ХНХЯ-ны харьяа Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвтэй хамтран 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулсан. Дээрх сургалтын үеэр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн арга зүйч багшийн өгсөн зөвлөмжийн дагуу дараах ажил, арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Далайн захиргааны мэргэжилтэн, усан замын тээврийн хяналтын улсын байцаагчдыг орон нутагт томилолтоор ажиллах үеийн хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх заавар, зөвлөмжөөр хангах ажлыг сайжруулах зорилгоор Далайн захиргааны даргын 2020 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 37 дугаар тушаалаар “Далайн захиргааны ажилтны албан томилолтоор ажиллах журам”, “Албан томилолтоор ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа”, “Албан томилолтоор ажиллах удирдамжийн загвар”, “Албан томилолтоор ажилласан тухай тайлангийн загвар”-ыг тус тус батлуулан мөрдөн ажиллаж байна.</li> </ul> <p>“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян-2020” арга хэмжээний хүрээнд манай байгууллагаас хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг 2020 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 1/85 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p>
5. Ажиллагсадыг эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгт хамруулах, эрүүл мэндийн анхан шатны тусlamж үзүүлэх арга хэмжээг зохион байгуулах, байгууллагын эмчийн ажиллах нөхцөл, өрөөний тохижилтыг сайжруулах чиглэлээр:	<p>Далайн захиргааны үйл ажиллагаатай холбоотойгоор үйлдвэрлэлийн хортой, онцгой хүнд нөхцөлтэй ажлын байр байхгүй. Гэхдээ нийт ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, урьдчилан сэргийлэх тарилга, вакцинд жил бүр хамруулах ажлыг зохион байгуулж ирсэн. Ажилтнуудыг 2019 онд эрүүл мэндийн үзлэгт хамруулаад байгаа бөгөөд эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамруулсан байдалд шалгالت хийх ажлыг Далайн захиргааны ХАБЭА-н орон тооны бус зөвлөлийн 2019-2020 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусган ажиллаж байна. Далайн захиргааны ХАБЭА-н орон тооны бус зөвлөл нь Далайн захиргааны даргын 2019 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 65 дугаар тушаалаар анх байгуулагдсан болно. Мөн дээрх төлөвлөгөөнд тусгасны дагуу байгууллагын хэмжээнд ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, эрүүл аюулгүй ажлын байрыг бий болгох, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчинөөс урьдчилан сэргийлэх, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавин ажиллах арга хэмжээг ХАБЭА-н орон тооны бус зөвлөл хариуцан</p>

	<p>ажиллаж байна.</p> <p>Ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахтай холбогдсон зардлыг байгууллагын 2020 оны үйл ажиллагааны орлого, зарлагын төлөвлөгөөнд тусгуулан ажиллаж байгаа.</p> <p>Ажилтнуудыг Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах талаар Төрийн тусгай алба хаагчдын нэгдсэн эмнэлэгтэй УСҮ/20/24/2020-26 тоот “Урьдчилан сэргийлэх үзлэг оношлогоо хийх тухай” гэрээг 2020 оны 10 дугаар сарын 05-ны өдөр байгуулсан. Энэхүү гэрээний дагуу 2020 оны 10 дугаар сарын 30-наас 11 дүгээр сарын 3-ны хооронд нийт 24 ажилтныг 19 төрлийн үзлэг, шинжилгээнд хамруулаад байна.</p> <p>Энэхүү эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгээр тухайн ажилтанд мэргэжлийн 6-7 эмч нар зөвлөмж, зөвлөгөө өгсөн нь эрүүл мэндэдээ хувь хүн өөрөө хэрхэн анхаарах, эрүүл, зөв хооллох, дасгал хөдөлгөөн тогтмол хийх, ажил, амралтын цагаа зөв зохицуулах дадлыг хэвшүүлж ажиллах тухай ойлголтыг ажилтнуудад бий болгосон ихээхэн үр дүнтэй арга хэмжээ болсон гэж дүгнэж байгаа.</p> <p>Цаашид энэхүү урьдчилан сэргийлэх үзлэгийг тогтмол зохион байгуулж хэвшүүлэхээр төлөвлөөд байна. Ажилтнуудын эрүүл мэндийн үзлэгийн хуудсанд Ерөнхий эмч тус бүрт дүгнэлт бичиж баталгаажуулсан болно. Энэхүү үзлэгээр эрүүл мэндийн хувьд ажил, мэргэжилдээ тэнцэхгүй гэсэн дүгнэлт гаралгүй болно. Эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан ажилтнуудын “мэдээллийн сан”-г бүрдүүлэн ажиллаж байна.</p>
6. Хортой нөхцөлд ажиллаж байгаа ажлын байранд хор саармагжуулах бүтээгдэхүүн олгох, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэх, мэргэжлээс шалтгаалах өвчлөлийн судалгаа хийж дүгнэлт санал боловсруулж танилцуулах;	<p>Далайн захиргааны ажлын байрууд нь хөдөлмөрийн хэвийн нөхцөлд хамарагдаж байгаа бөгөөд байгууллагын хэмжээнд 2015-2019 онд гарсан үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөлийн тохиолдол байхгүй болно.</p> <p>Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэх талаар мэргэжлийн байгууллагаас зөвлөгөө авах талаар 2020 оны төлөвлөгөөнд тусгаад байна. Эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан ажилтнуудын “мэдээллийн сан”-г бүрдүүлэх талаар хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолт, Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан бөгөөд 2020 оны эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийн дүнгээр “мэдээллийн сан” бүрдүүлээд байна.</p> <p>Далайн захиргааны усан замын тээврийн хяналт хариуцсан мэргэжилтэн /Усан замын тээврийн хяналтын байцаагч, завь катер жолоодон ажил үүргээ гүйцэтгэдэг/-ийн ажил үүргийн онцлогийг харгалзан тэдний ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг 2021 онд хийлгэхээр төлөвлөн холбогдох зардлыг Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны орлого, зарлагын төлөвлөгөөний ХАБЭА-н зардалд тусгахаар ажиллаж байна.</p>
<p><b>“Хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 253 дугаар тушаалаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт:</b></p> <p>1.6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2-т засны дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардлыг</p>	
<p>ХАБЭА-н тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангахтай холбоотойгоор дараах зардлуудыг Далайн захиргааны 2020 оны үйл ажиллагааны орлого, зарлагын төлөвлөгөөнд тусгасан бөгөөд зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна.Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Ажилтнуудад зориулан ХАБЭА-н чиглэлээр сургалт зохион байгуулах;</li> <li>- Өрөө тасалгаанд болон техник, төхөөрөмжид шаардлагатай засвар, тохижилтүн ажлуудыг хийх;</li> </ul>	

<p>жил бүр төсөвт тусган зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлд хяналт тавих;</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Хөвөлтийн улиралд Хөвсгөл аймагт томилолтоор ажилладаг усан замын тээврийн хяналтын байцаагчид, усан замын бүртгэл, хяналт хариуцсан мэргэжилтэн нарын эрүүл, аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Хөвсгөл аймгийн Хатгал тосгон дахь Усан замын хяналтын постод тохижилтын ажлыг хийх;</li> <li>- Ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулахад байгууллагаас дэмжлэг үзүүлэх;</li> <li>- Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ хийлгэх эсэх асуудлыг мэргэжлийн байгууллагатай хамтран шийдвэрлэх, зардлыг 2021 оны үйл ажиллагааны орлого, зарлагын төлөвлөгөөнд тусгахаар ажиллаж байна.</li> </ul>
<p>1.7. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгож, хууль тогтоомж, дүрэм, журам, стандартыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хийгдсэн үзлэг, хяналт, шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ, түүний хэрэгжилтэд хяналт тавьж зөрчил дутагдлыг арилгуулсан байх;</p>	<p>Далайн захиргааны ХАБЭА-н орон тооны бус зөвлөлийн 2019-2020 оны төлөвлөгөөнд гурван шатны хяналт хийх талаар тусгасан. Уг шалгалтыг Далайн захиргааны ажлын байранд хийхээс гадна усан замын тээврийн хяналтын улсын байцаагчдын ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, аюулгүй ажиллагааны зааварчилгаагаар хангах, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж өгөх ажлыг усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн улиралд хийхээр төлөвлөсөн. Далайн захиргааны ХАБЭА-н орон тооны бус зөвлөл болон байгууллагын ХШДАЗ-ийн төлөөллийг оролцуулсан бүрэлдэхүүн Далайн захиргааны даргын 2020 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн 58 дугаар тушаалаар Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд ажиллаж, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийн байдалтай танилцаж, ХАБЭА-н II шатны үзлэг, шалгалтыг 2020 оны 09 дүгээр сарын 18-21-ний хооронд хийсэн. Уг шалгалтын дүнг байгууллагын удирдлагад танилцуулж, шалгалтын мөрөөр цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг ажлын тайландаа тусгасан. Энэхүү II шатны үзлэг, шалгалтын мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг илтгэх хуудсаар ирүүлэх талаар холбогдох албан тушаалтанд мэдэгдсэн болно. ХАБЭА-н III шатны үзлэг, шалгалтыг 2021 оны хөвөлтийн улиралд хийхээр төлөвлөн ажиллаж байна.</p>
<p>2. Энэхүү тушаалын 1 дэх заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн гурван /3/ шатны хяналтыг зохион байгуулах журам"-ыг боловсруулан баталж, хэрэгжилтийг хагас жил тутамд Зам, тээврийн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороонд тайлагнаж байхыг харьяа байгууллагын</p>	<p>Төрийн хяналт, шалгалтын тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулиудыг хэрэгжүүлэхтэй холбогдсон дүрэм, журам, стандарт болон Зам, тээврийн хөгжлийн сайдын энэхүү тушаалд нийцүүлэн "Далайн захиргааны Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн гурван шатны хяналтыг зохион байгуулах журам"-ыг Далайн захиргааны даргын 2019 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 68 дугаар тушаалаар батлуулан ажиллаж байна.</p> <p>Энэхүү журмыг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах чиглэлээр байгууллагын хэмжээнд батлагдан гарсан бусад тушаалуудын хуулбарын хамт 2019 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 1/186 тоот албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн дэд сайдад хүргүүлээд байна.</p> <p>Уг журамд 1-р шатны хяналтыг ажилтан эсхүл ажил шууд удирдаж буй ажилтан, 2-р шатны хяналтыг Далайн захиргааны ХАБЭА-н орон тооны бус Зөвлөлийн гишүүд, 3-р шатны хяналтыг Байгууллагын даргын тушаалаар томилогдсон комисс тус тус гүйцэтгэхээр тусган ажиллаж байна.</p>

дарга, удирдлагад үүрэг  
болгосугай.

Далайн захиргааны ХАБЭА-н зөвлөл болон ХШДАЗ-ийн гишүүд орон нутагт томилолтоор ажиллах үеэр ХАБЭА-н орон тооны бус зөвлөлийн 2020 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсан ХАБЭА-н II шатны үзлэг, шалгалтыг 2020 оны 09 дүгээр сарын 19-20-ны өдрүүдэд Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд явуулав. Үүний зэрэгцээ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийн байдалтай танилцаж, хийсэн II шатны үзлэг шалгалтын ажлын тайланг 2020 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр 1/187 тоот албан бичгээр Зам, тээврийн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороонд хүргүүлсэн.  
Энэхүү ХАБЭА-н II шатны үзлэг, шалгалтын дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг 2021 онд шалгахаар хугацаатай үүрэг өгсөн болно. Ийнхүү ХАБЭА-н 3-р шатны үзлэг, шалгалтыг Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд 2021 оны хөвөлтийн улирлын хугацаанд хийхээр төлөвлөөд байгаа бөгөөд шаардагдах зардлыг байгууллагын 2021 оны төсөвт тусгуулахаар ажиллаж байна.

---оо---